



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр, Бага тойруу-15,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0066

Утас: 7575-7807, Факс: (976) 7575-7809

E-mail: contact@ub-procurement.mn

<http://www.ub-procurement.mn>

2020.06.30 № 04/1538

танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТ**

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2020 оны 02 дугаар улирлын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА



Э.БОЛОРМАА

1150500635

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2020 оны 06 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт 2020 оны эхний хагас жилийн /байдлаар нийт 26 өргөдөл, гомдол, хүсэлт ирж хуулийн хугацаандаа шийдвэрлэгдсэн байна.

Өргөдөл гомдлын дэлгэрэнгүй тайлангийн хувьд авч үзвэл:

Хугацаандаа шийдвэрлэсэн – 25, Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн – 1, судалж байгаа 0 үзүүлэлттэй байна.

Хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдлийн тайлбар: Тус өргөдөл нь 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн засаг даргын Тамгын газарт ирсэн. 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлснийг 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч С.Оюунчимэг мэргэжилтэнд шилжүүлэн тухайн өдөр өргөдлийг хаасан боловч Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс өргөдлийн шийдвэрлэлт тодорхой бус гэсэн шалтгаанаар буцаасныг мэдэлгүй 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр шийдвэрлэлтийг тодорхой болгон системд дэлгэрэнгүй хаасан.

Үүнээс:

1. Гомдол - 1
2. Хүсэлт - 26
3. Өргөдөл - байхгүй

Өргөдөл гомдлын хандалтын тайлангийн хувьд авч үзвэл:

№	Ангилал	Өргөдөл гомдлын тоо	Өргөдөл гомдлын хувь
1	Ажлаас чөлөөлөгдөх тухай	6	23.07%
2	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	5	19.23%
3	Цалинтай чөлөө хүсэх тухай	5	19.23%
4	Нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай	4	15.38%
5	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	2	7.69%
6	Ажлын сахилга, хариуцлагын тухай	1	3.84%
7	Ажилд орох хүсэлтийн тухай	1	3.84%
8	Жирэмсний амралтын тухай	1	3.84%
9	Цалингүй чөлөө хүсэх тухай	1	3.84%
Нийт өргөдөл гомдлын, дүн		26	100.00%

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааны тайлангийн хувьд авч үзвэл:

2020 оны эхний хагас жилийн байдлаар байгууллагад ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 21 цаг 26 минутад шийдвэрлэгдсэн байна.

**НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ
ИРСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ ТАЙЛАНД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
(2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн байдлаар)**

2020 оны 06 дугаар сарын 29

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын өргөдөл гомдлын шийдвэрлэлт, ирсэн явсан албан бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэсэн эсэх, холбогдох байгууллага, иргэн аж ахуйн нэгжид хүрсэн эсэх, зөрчил гомдлыг үндэслэн хэрхэн сайжруулах, удирдлагыг мэдээллээр хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ҮНДЭСЛЭЛ

Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоол “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай”, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн байдлаар тус газарт ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ болон ажил хариуцсан албан хаагчийн тайлбарыг үндэслэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой дээрх үүрэг даалгаврын хүрээнд ажил төлөвлөж, зохион байгуулж буй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

ГУРАВ. ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1 Тайлант хугацаанд нийт 26 өргөдөл, хүсэлт, гомдол ирүүлснээс өргөдөл хүсэлт 26, өргөдөл гомдол ирүүлээгүй байна. Үүнээс ажлаас чөлөөлөх тухай 6, ажилд шилжих, дэвшин ажиллах тухай 5, цалинтай чөлөө хүсэх тухай 5, нийслэлийн Засаг даргын Хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааны тухай 4, Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай 2, ажлын сахилга хариуцлагын тухай 1, ажилд орох хүсэлтийн тухай 1, жирэмсний амралтын тухай 1, цалингүй чөлөө олгох тухай 1, нийт 26 өргөдөл хүсэлт ирүүлснийг www.erp.ulaanbaatar.mn системд бүртгэсэн байна. Өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 21 цаг байна.

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хугацаагаар авч үзвэл:

Хүснэгт 1

Ирсэн өргөдөл гомдол	Шийдвэрлэсэн хугацаа				Хугацаа сунгасан	Хугацаа хэтэрсэн
	5 хоногт	10 хоногт	15 хоногт	30 хоногт		
Нийт 26	23	-	-	2	-	1

3.2 Төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1-д “Тендер шалгаруулалттай холбогдуулан хүлээсэн үүргээ захиалагч зөрчсөн гэж үзвэл тендерт оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана” гэж заасан. Уг заалтын хүрээнд хамаарах гомдол, өргөдөл тус газарт ирээгүй байна. Мөн уг хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-т “Тендерт оролцогч нь энэ хуулийн 11.2-т заасныг зөрчсөн болон тендерийн баримт бичиг бэлтгэх явцад өрсөлдөөний хязгаарласан ямар нэгэн зөрчил гарсан гэж үзвэл гомдлоо тендерийн нээлт хийхээс өмнө Шударга

өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт, захиалагчийн шийдвэрийг эс зөвшөөрсөн, хуульд заасан хугацаанд захиалагч шийдвэр гаргаагүй, эсхүл гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдлыг зөвхөн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ажлын 5 хоногийн дотор гаргана" гэж заасан. Иймд тус газрын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар иргэн, аж ахуйн нэгжээс гомдол ирээгүй тул энэ чиглэлээр тусгайлсан төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ үүсээгүй байна.

3.3 2019 оны 12 дугаар сарын 31-ны өдөр байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталсан бөгөөд Өргөдөл гомдлын нэгдсэн системийг журмын дагуу хөтлөн, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэхээр тусгасан байна.

3.4 Тайлант хугацаанд нийт 13 зөрчил системд бүртгэгдсэнээс өдөрт нь багтаан хүлээн аваагүй 11, явцын тэмдэглэл хийгээгүй 2 байна. Дэлгэрэнгүйг хүснэгт 2, хүснэгт 3-т үзүүлээ.

Зөрчлийн тоон үзүүлэлтээр авч үзвэл:

Хүснэгт 2

Д/Д	Зөрчлийн төрөл	Зөрчлийн тоо
1	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил	11
2	Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил	2
Нийт		13

Зөрчлийн дэлгэрэнгүй үзүүлэлтээр авч үзвэл:

Хүснэгт 3

Д/Д	Хэлтэс нэгж	Албан хаагч	Өргөдлийн дугаар	Зөрчлийн төрөл, хэлбэр		
				Дэлгэрэнгүй	Огноо	Тоо
1	Дотоод аудит	С.Оюунчимэг	О191202106	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	2020-01-14	1
2	Дотоод аудит	С.Оюунчимэг	M200312002	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	2020-03-27	1
3	Захиргаа, санхүүгийн хэлтэс	Д.Болорчимэг	G200508013	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	2020-05-25	10
4	Мэдээллийн технологийн хэлтэс	Б.Түмэнжаргал	M200608004	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	2020-06-10	1
Нийт						13

ДӨРӨВ. ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ДҮГНЭЛТ

2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн байдлаар тус газар нь 26 удаагийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног 21 цаг 26 минутад багтаан шийдвэрлэж ажилласан байна.

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасны дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн богино хугацаанд шийдвэрлэх,
2. Өргөдөл гомдол ирсэн өдөрт нь багтаан танилцах,
3. Тухай бүрт явцын тэмдэглэл хөтлөх,
4. Шийдвэрлэлтийг цахим системд бүртгэхдээ монгол бичгийн дүрмийг баримтлахад анхаарах нь зүйтэй байна.